

Хичээл: Даатгалын тухай ерөхий ойлголтууд

CII Award Level Unit: General Insurance W01

Хичээл заах багш: Э.Индра, Ч.Жалбуу



Хэрэгжүүлэгч



Хамтран хэрэгжүүлэгч



Оршил

Өнөөгийн даярчлагдаж буй дэлхий дээр даатгалын бизнес хүрээгээ тэлж газар нутаг, хил хязгаар хамаарахгүйгээр даатгалыг хийж болж байна. Олон улсын даатгалын компаниуд бусад улс оронд буй эрэлт хэрэгцээнд тулгуурлан даатгалын нийлүүлтийг хийж өөрсдийн бизнесээ өргөжүүлсээр байна. Бид энэхүү хил хязгааргүй бизнест өөрийн карьерийн замналыг үүсгэж байгаа учир олон улсын зах зээл дээрх мэргэжилтнүүдтэй ижил тэнцүү даатгалын тухай ойлголт, мэдлэгтэй байх нь чухал юм.

Энэхүү хичээлээр бид та бүхэнд эрсдлийн тухай ойлголт, түүнийг удирдах, даатгал эрсдэлийн шилжүүлэх механизм болох, даатгал хэрхэн ажилладаг тухай ерөнхий ойлголтыг өгнө. Мөн даатгалын зах зээлийн бүтэц, түүнд оролцогч талуудын тухай суурь ойлголтууд багтана.



Хичээлийн Агуулга – Эхний өдөр

1. Эрсдэл ба даатгалын суурь агуулга, онцлогыг таньж мэдэх

- 1.1. Эрсдэл ба эрсдэлийн тухай ойлголт
- 1.2. Эрсдэлийг ангилах ба тэдгээрийн ялгаа шинж
- 1.3. Эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэг
- 1.4. Эрсдэлийн удирдлагын үүрэг, үйл ажиллагаа
- 1.5. Даатгалын хэрэгцээ ба даатгалын үндсэн төрлүүд

2. Даатгалын гэрээг удирдах суурь зарчмуудыг мэдэх

- 2.1. Даатгалын гэрээ хүчин төгөлдөр болох суурь нөхцөлүүд
- 2.2. Даатгалын гэрээ хэзээ цуцлагдах тухай
- 2.3. Даатгалын агент бий болох нөхцөл, агент хэрхэн даатгалын гэрээг хүчин төгөлдөр болгох тухай
- 2.4. Даатгалын агентийн үүрэг, эзний үүрэг
- 2.5. Даатгуулах сонирхлыг тодорхойлох нь
- 2.6. Даатгалын гэрээний дагуу мэдээллийг бүрэн зөв мэдээллэж танилцуулах зарчмын тухай
- 2.7. Анхдагч шалтгааны тайлбар ба үүнийг нөхөн төлбөрт хэрхэн авч үзэх тухай
- 2.8. Нөхөн төлбөр олгох зарчмууд ба даатгалын гэрээнд тусгагдах тухай
- 2.9. Дутуу даатгуулах ба дундаж тооцох тухай
- 2.10. Давхардсан даатгалыг зохицуулах, даатгагч нарын оролцоо
- 2.11. Буцаан нэхэмжлэх эрхийн тухай зарчмууд

Хичээлийн Агуулга – Сүүлийн өдөр

3. Даатгалын салбарын суурь агуулга ба бүтцийг таньж мэдэх

- 3.1. Даатгалын салбарыг бүрдүүлж буй оролцогчид
- 3.2. Даатгагчдын төрөл
- 3.3. Lloyd's-н бусдаас ялгарч буй онцлог бүтэц, агуулга
- 3.4. Даатгалын бүтээгдэхүүн борлуулах сувгуудын тухай, тэдгээрийн онцлог

4. Даатгалын бизнес явуулахтай холбоотой үндсэн зохицуулалтууд, хуулийн зарчмууд

- 4.1. Даатгалын салбарын зохицуулалтын ач холбогдол
- 4.2. Даатгагчийн хөрөнгийн хүрэлцээтэй байдал
- 4.3. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ба луйвар хэрхэн даатгалын салбарт нөлөөлдөг тухай


5. Даатгалын салбарын ёс зүй, байгууллагын засаглал, дотоод хяналтын тухай

- 5.1. Ёс зүйн стандартууд
- 5.2. Компанийн засаглалын тухай
- 5.3. Дотоод хяналтын системийн ач холбогдол

1.1. Эрсдэл ба Эрсдэлийн Тухай Ойлголтууд

Эрсдэлийг тодорхойлоход:

- ✓ Нөхцөл байдлын үр дүнг тодорхойлоход төвөгтэй
- ✓ Таамаглах боломжгүй
- ✓ Хохирол дагуулах магадлалтай
- ✓ Ашигтай байх завшаан (мөрий, хөрөнгө оруулалтаас гэх мэт) зэрэг утгуудаар эрсдэлийн тодорхойлолтыг гаргаж болох юм.





Даатгал эрсдэлийг хэрхэн хүлээн авдаг вэ?

Даатгал нь **мэдэгдэхгүй байгаа хохирлыг** (гэмтэл, бэртэл, эвдрэл гэх мэт эрсдэл) **мэдэгдэж буй өртөг үнээр** (даатгалын хураамж) орлуулах үйл ажиллагаа юм.

Даатгагч учирч болохуйц эрсдэлийг тохиролцсон хураамжаар зөвшөөрч үр ашигтайгаар хүлээн авахыг эрсдэлийг шилжүүлэх механизм гэнэ.

Даатгалд эрсдэлийг томъёолохдоо:

Даатгалын нэрлэсэн эрсдэл – галын эрсдэл, хулгайн эрсдэл г.м

Даатгуулсан эд зүйл – автомашин, компаний хариуцлага г.м

1.2. Эрсдэлийг ангилах ба тэдгээрийн ялгаа шинж

Financial and Non-financial risks

Мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой эсвэл боломжгүй
эрсдэл

Particular and Fundamental risks

Тодорхой эрсдэл болон Суурь эрсдэл

Pure and Speculative risks /

Цэвэр эрсдэл болон Арилжааны эрсдэл

Эрсдэл ба даатгалын суурь агуулга,
онцлогыг таньж мэдэх

Мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой эрсдэл

Тохиолдол	Үр дүнг илэрхийлэх
Автомашин зам тээврийн осол	Автомашиныг засах эсвэл солих зардал
Хөрөнгийн хулгай	Хулгайлсан эд зүйлсийн зах зээлийн үнэлгээ
Галаас үүдсэн бизнес тасалдал	Тасалдсан хугацааны алдагдлыг өмнөх үетэй нь харьцуулан нөхөн төлбөр олгох

Мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй эрсдэл

Тохиолдол	Үр дүнг илэрхийлэх
Шинэ байшин авах сонголт	Сонголт хийхэд байшингийн загвар, байршил, хийц гэх зүйлс нөлөөлөх ба үүнийг мөнгөөр илэрхийлэх боломжгүй
Хүүхдийн сургууль сонгох	Сургуулийн чанар, багш, сургалтын хөтөлбөр зэрэг нөлөөлнө
Амралтаа өнгөрүүлэх сэтгэл ханамж	Амралтын хугацаанд хийсэн зүйлс нөлөөлнө

Цэвэр эрсдэл

Эрсдэлийн улмаас ямар нэгэн ашиг хийх боломжгүй байх нөхцөлийг хэлнэ. Хамгийн боломжит үр дүн нь хугарлын цэгтээ хүрэх эсвэл бага хэмжээний алдагдал үүрэх нөхцөл үүсдэг.

Эрсдэл	Агуулга
Галын эрсдэл	Галын эрсдлээс хөрөнгө сүйрэх, бизнес тасалдах ба үр дагаврыг санхүүгийн мөнгөн дүнгээр хэмжих боломжтой
Тоног төхөөрөмжийн эвдрэл	Тоног төхөөрөмж зогссоноос үүдэж бизнес тасалдах, хөрөнгийг дахин солих зардлуудыг хэмжих боломжтой
Ажилтан ажлын байран дээрээ гэмтэх	Гэмтэл нь ажил олгогчийн буруутай үр дагавраас болсон бол тэтгэмж, бусад зардлыг тооцох боломжтой

Арилжааны эрсдэл

Арилжааны эрсдэл нь 3 боломжит үр дагавартай байдаг:

1. Алдагдал
2. Хугарлын цэг дээр ирэх
3. Ашиг

Жишээ нь: сугалаа, шинэ бизнес эрхлэх гэх мэт

Тодорхой эрсдэл

Эрсдэл	Агуулга
Үйлдвэрт гал гарах	Тухайн үйлдвэр, түүнийг хүрээлж буй ойр орчмын газар галд өртөх ба энэ нь бүх нийтийг хамарсан эрсдэл болохгүй
Автомашин мөргөлдөх	Зам тээврийн осолд өртсөн хэсэг хүмүүст хамаарна
Орон байрны хулгай	Нэг гэр бүл эсвэл хувь хүн үүнд өртөнө

Суурь эрсдэл

- ✓ Суурь эрсдэл гэдэг нь нэг эвсэл бүлэг хүмүүс үүнийг удирдах боломжгүй, бүх нийтийг хамарсан шинж чанартай байдаг. Жишээ нь: байгалийн гамшиг, эдийн засгийн хямрал, дайн гэх мэт




- ✓ Зарим төрлийн суурь эрсдэл нь хэсэг бүлэг хувь хүмүүсийг хамарч байх тохиолдолд үүнийг даатгах боломжтой байдаг. Жишээ нь: эдийн засгийн уналтаас үүдэн зээлдэгчид зээлээ эргэн төлөх боломжгүй болох үед үүсэх төлбөр тасалдлын эрсдэл, зарим улс оронд газар хөдлөлт, хар салхи, онцгой тохиолдолд дайн, улс төрийн эрсдэл гэх мэт эрсдэлээс даатгадаг.

Даатгагдах болон даатгах боломжгүй эрсдэлийг нэгтгэж харвал:

Даатгагдах эрсдэл	Даатгагдахгүй эрсдэл
✓ Мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой	▪ Мөнгөөр илэрхийлэх боломжгүй
✓ Цэвэр	▪ Арилжааны
✓ Тодорхой	▪ Суурь
✓ Гэнэтийн	▪ Санаатай
✓ Даатгуулах сонирхол оршиж байгаа	▪ Даатгуулах сонирхол агуулаагүй
✓ Нийтийн хэв журмын эсрэг биш	▪ Нийтийн хэв журмын эсрэг
✓ Ижил шинж чанар бүхий өртөцтэй	▪ Тохиолдох нь тодорхой эрсдэл

1.3. Эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэг

Даатгагдах эрсдэлийн шинж чанар: Эрсдэл нь даатгагдахын тулд дараах шинж чанарыг одоо цагт агуулж байх ёстой




Эрсдэл ба даатгалын суурь агуулга,
онцлогыг таньж мэдэх



Эрсдэл ба даатгалын суурь агуулга,
онцлогыг таньж мэдэх

Эрсдэлийн зэрэг



Даатгагч эрсдэлийг үнэлэхдээ давтамж / frequency (хэр их болох магадлал) ба далайц / severity (хэр хэмжээний хохирол учрах)-г авч үздэг.

- Өндөр давтамжтай боловч бага далайцтай байх

Жишээ нь: Тээврийн хэрэгслийн даатгал

- Бага давтамжтай боловч өндөр далайцтай байх

Жишээ нь: Агаарын хөлгийн осол

Аюул ба нөлөөлөл

- **Аюул /Peril/** – Хохирол дагуулж болох үндсэн хүчин зүйл. Нөлөөлөл гэдэг нь аюулд нөлөөлж буй нөлөөлөлүүд

Жишээ нь: Хэн нэгэн байшин дотор тамхи татаж дуусаад ишээ хаяснаар гал гарсан. Гал нь өөрөө аюул болох юм. Байшин дотор тамхи татах үйлдэл нь нөлөөлөл гэж үзэх ба байшин дотор гал гарахап хүргэж буй нөлөөлөл болох юм. Хэрвээ байшин нь модон хийцтэй бол нөлөөллийг нэмэгдүүлж байна гэж үзнэ.

- **Нөлөөлөл /Hazard/** – Хохирол дагуулах хүчин зүйлсийн тохиолдох магадлал, үг дагаварт нөлөөлөгч хүчин зүйлс

Нөлөөллийг:

- Биет /physical/
- Зан төлвийн /moral/
- Эерэг /positive/
- Сөрөг /negative/ гэж ангилж үзнэ.

Биет нөлөөллийн жишээ даатгалд:

Галын эрсдэлийн даатгал	<ul style="list-style-type: none">• Барилгын хийц• Галаас хамгаалах тоноглол• Үйл ажиллагааны чиглэл
Хулгайн эрсдэлийн даатгал	<ul style="list-style-type: none">• Барилгын хийц• Хамгаалалтын ситем• Барилга доторх эд зүйлс
Тээврийн хэрэгслийн даатгал	<ul style="list-style-type: none">• Автомашины үйлдвэр загвар• Хаана ихэвчлэн зогсдог• Юунд ашигладаг• Насжилт
Ажил олгогчийн хариуцлагын даатгал	<ul style="list-style-type: none">• Үйлдвэрийн процесс• Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
Гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал	<ul style="list-style-type: none">• Хувь хүний эрүүл мэндийн түүх, ажил мэргэжил• Аюултай спортоор хичээллэдэг эсэх


Зан төлвийн нөлөөлөл:

Зан төлвийн нөлөөлөл нь хүний хандлага, зан байдалтай хамаатай ба энэ нь юу даатгасан гэдгээс илүүтэйгээр эрсдэлийн үр дагаварт нөлөөлдөг. Даатгал дээр зан төлвийн нөлөөлөл нь даатгуулагчийг гол эх сурвалж нь гэж үздэг. Жишээ нь:

- Дэлгүүрийн эзэн галын болон хулгайн дохиоллын систем суулгахгүй байх
- Барилгыг стандартын дагуу барихгүй байх
- Үйл ажиллагаандаа хайхрамжгүй хандах
- Жолооч өндөр настай байх

1.4. Эрсдэлийн удирдлагын үүрэг, үйл ажиллагаа

Даатгуулах шийдвэр хэрхэн гардаг вэ?



Өөрийгөө даатгах Self insurance

- Хувь хүн эсвэл компани эрсдэлийн удирдлагын шийдвэр гаргахдаа эрсдэлээ өөрсдөө даах буюу аливаа хохирол учирахад түүнийг даах зорилгоор өөртөө сан үүсгэхийг өөрийгөө даатгах хэлбэр юм.
- Уг хэлбэр нь өндөр давтамжтай, бага далайцтай хохирлуудад тохиромжтой байдаг.


Хам даатгах Co-insurance

- Даатгагч өөртөө эрсдэлийг 100% авахгүйгээр өөр бусад даатгагчтай хамтран нэг эрсдэлийг бичих хэлбэрийг хам даатгах гэнэ.
- Даатгагч бүр өөр өөрийн хувь оролцоогоор хураамж авах, хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ.


Давхардуулан даатгах Dual insurance

- Даатгуулагч нэг эрсдэлийг 2 болон түүнээс дээш даатгалд даатгуулахыг давхардсан даатгал гэж үздэг.
- Давхардсан даатгалтай тохиолдолд нөхөн төлбөрийг хэрхэн олгох тухай зохицуулалтыг даатгалын гэрээнд тусдаа нөхцөл болгон даатгагч тус бүр оруулсан байдаг.

Өөрийгөө даатгуулах



Хам-даатгах



Эрсдэлийн сан үүсгэх

Даатгалын компани нь ижил төрлийн эрсдэлээс хамгаалах хүсэлтэй бүлэг хүмүүсээс цуглуулсан хураамжийг нэгтгэж сан үүсгэдэг ба уг хамтын санг удирдах үйл ажиллагааг явуулдаг.

Энэхүү сан нь тухайн нэг жилд учирсан хохирлыг бүрэн барагдуулах, түүнтэй холбоотой гарч буй зардлыг даах, үүнээс өөртөө ашиг үлдээх замаар зөв зохистой удирдаж ажиллахын тул уг санд цуглуулж буй хураамжийг шудрага, зохистой хэмжээнд тооцох хэрэгтэй болдог.

- ✓ **Их тооны хууль /Law of large numbers/** – даатгагч ижил төстэй эрсдэлийг нэгтгэж түүнээс учирч болох нөхөн төлбөрийн хэмжээг тооцдог
- ✓ **Зөв тохирох хураамж тооцох /Equitable premiums/** - Ижил төстэй эрсдэлийг нэгтгэн түүнээс цуглуулж буй хураамжаар тус бүрт сан үүсгэх бөгөөд уг санд оролцохын тулд зөв, шудрага оролцоог бий болгох шаардлагатай. Зөв шудрага оролцоог илэрхийлэх зүйл нь даатгалын хураамж бөгөөд даатгалын андеррайтерийн үндсэн хийх ёстой ажил нь санд нэгдэх гэж буй даатгуулагчийн эрсдэлийг зөв үнэлж түүнд тохирсон шудрага хураамжийг тогтоох юм. Шудрага зохистой хураамжийг цуглуулсанаар санд оролцож буй даатгуулагч бүр шудрагаар нөхөн төлбөрөө авах нөхцөл бүрдэнэ.

Эрсдэл ба даатгалын суурь агуулга,
онцлогыг таньж мэдэх



2. Даатгалын гэрээг удирдах суурь зарчмуудыг мэдэх

- 2.1. Даатгалын гэрээ хүчин төгөлдөр болох суурь нөхцөлүүд
- 2.2. Даатгалын гэрээ хэзээ цуцлагдах тухай
- 2.3. Даатгалын агент бий болох нөхцөл, агент хэрхэн даатгалын гэрээг хүчин төгөлдөр болгох тухай
- 2.4. Даатгалын агентийн үүрэг, эзний үүрэг
- 2.5. Даатгуулах сонирхлыг тодорхойлох нь
- 2.6. Даатгалын гэрээний дагуу мэдээллийг бүрэн зөв мэдүүлж танилцуулах зарчмын тухай
- 2.7. Анхдагч шалтгааны тайлбар ба үүнийг нөхөн төлбөрт хэрхэн авч үзэх тухай
- 2.8. Нөхөн төлбөр олгох зарчмууд ба даатгалын гэрээнд тусгагдах тухай
- 2.9. Дутуу даатгуулах, дундаж тооцох, хариуцах хэсгийн тухай
- 2.10. Давхардсан даатгалыг зохицуулах, даатгагч нарын оролцоо
- 2.11. Буцаан нэхэмжлэх эрхийн тухай зарчмууд

2.1. Даатгалын гэрээ хүчин төгөлдөр болох суурь нөхцөлүүд

Даатгалын гэрээ гэдэг нь даатгуулагч нь хураамжийг даатгагчид төлөхөө зөвшөөрсөн, даатгагч нь тохирсон нөхцөл бүрдэхэд даатгуулагчид нөхөн төлбөрийн мөнгө төлөхөө зөвшөөрсөн хуулийн дагуу хүчин төгөлдөр болсон тохиролцоо юм.

Хүчин төгөлдөр гэрээ нь дараах шалгуурыг хангасан байна:

✓ Санал илэрхийлэх ба хүлээн зөвшөөрсөн байдал /Offer and acceptance/

- | | |
|--|---|
| ▪ Нөхцөлгүйгээр хүлээн зөвшөөрөх /unconditional acceptance/ | Жишээ:
Даатгагч: ирүүлсэн асуулгын хуудас дээр үндэслэн нэр дурдсан жолооч нар тээврийн хэрэгслийг жолоодох нөхцөлтэй даатгалын хамгаалалт 200,000 төгрөгийн хураамжтай байх даатгал санал болгож байна.
Даатгуулагч : Нөхцөлийг зөвшөөрлөө. |
| ▪ Нөхцөлтэй хүлээн зөвшөөрөх /conditional acceptance/ | Жишээ:
Даатгагч: ирүүлсэн асуулгын хуудас дээр үндэслэн нэр дурдсан жолооч нар тээврийн хэрэгслийг жолоодох нөхцөлтэй даатгалын хамгаалалт 200,000 төгрөгийн хураамжтай байх даатгал санал болгож байна.
Даатгуулагч : Зөвшөөрч байна. Гэхдээ жолоочийн нэр дурдахгүй байх нөхцөлтэй даатгалын хамгаалалт авмаар байна. |
| ▪ Харилцаа холбооны хэрэгсэл ашиглан хүлээн зөвшөөрсөнг илэрхийлэх /postal acceptance/ | |

✓ Ач холбогдол /Consideration/

2.2. Даатгалын гэрээ хэзээ цуцлагдах тухай

▪ Даатгагч гэрээг цуцлах

Хуурамчаар нөхөн төлбөр авах – Английн “Даатгалын тухай хууль 2015”-д луйврын шинжтэй үйлдэл гаргавал тухайн цаг үеэс даатгалын гэрээг цуцалж даатгалын хураамжийг буцаахгүй байх эрхийг даатгагчид олгосон байдаг.

▪ Даатгуулагч гэрээг цуцлах

Даатгуулагч аливаа учир шалтгааныг тайлбарлахгүйгээр, мөн аливаа торгууль хүлээхгүйгээр даатгалын гэрээг цуцлах эрхтэй байдаг. Даатгалын гэрээний төрлөөс хамаарч цуцлах тухай мэдэгдлээ хэсэг хугацааны өмнө өгөхөөр заасан байна.

▪ Даатгалын гэрээг цуцлах бусад нөхцөл:

- Даатгал бүрэн хэрэгжсэн
- Гэрээ хүчингүй болох нөхцөл бүрдсэн гэж үзвэл /даатгал авахаар хандах үеэс бүрэн зөв мэдээллийг өгөөгүй, гэрээний нөхцөл зөрчсөн, даатгуулах сонирхол зөрчигдсэн гэх мэт/

2.3. Даатгалын агент бий болох нөхцөл, агент хэрхэн даатгалын гэрээг хүчин төгөлдөр болгох тухай

Бүх гэрээг талууд хоорондоо шууд зөвшилцөн байгуулалгүй дундын зуучлагчаар дамжуулан байгуулдаг. Даатгалд уг дундын зуучийг даатгалын зуучлагч буюу брокер гэнэ. Дундын зууч нь агентын үүргийг гүйцэтгэх ба даатгагч, даатгуулагч аль аль талыг төлөөлж ажилладаг.

Агент нь эзэн /the principal/ -ий олгосон эрхийн дагуу эзнийг гуравдагч талтай гэрээний харилцаанд оруулах харилцааг бий болгодог.

- ✓ Эзэн ба агентын харилцаа
- ✓ Агентын үүрэг
- ✓ Эзний үүрэг
- ✓ Агентын гэрээ

Эзэн ба Агентын харилцаа

Даатгалын зуучлагч буюу брокер нь биеэ даасан, хараат бус зөвлөх нар юм. Бие даасан зуучлагч нь тухайн үеийн гүйцэтгэж буй үүргээс хамаарч өөр өөр нөхцөл байдалд даатгуулагчийн агент байж болно, эсвэл даатгагчийн агент байж болдог.

Даатгуулагчийн агент	Даатгагчийн агент
<ul style="list-style-type: none">• Даатгалын гэрээний байршуулалт хийх• Даатгалын гэрээг зөвлөх• Нөхөн төлбөр авахад зөвлөх	<ul style="list-style-type: none">• Даатгагчийн өмнөөс даатгах зөвшөөрлийг олгох эрхийг даатгагч агентад өгөх• Даатгагчийн өмнөөс хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх• Даатгалын хураамжийг цуглуулах• Даатгагчийн өмнөөс нөхөн төлбөрийг шийдвэрлэх зөвшөөрлийг даатгагч өгөх

2.4. Даатгалын агентийн үүрэг, эзний үүрэг

Агентын үүрэг	Эзний үүрэг
<ul style="list-style-type: none">Агентын гэрээнд заасны дагуу ажиллахАгент зохих үүрэг хариуцлагыг дагаж ажиллах бөгөөд агентын үүргийг хэн нэгэн этгээдэд дамжуулан өгөхгүй байх, өөрийн өмнөөс ажлаа хийлгэхгүй байхЗуучлал хийх мэргэжлийн ур чадвар, арга техникийг эзэмшсэн байхЭзэн болон гуравдагч этгээдийн хооронд зуучлал хийхдээ үнэн шудрага байх зарчмыг баримтлахСанхүүгийн бүртгэл тооцоо хөтөлдөг байх	<ul style="list-style-type: none">Шимтгэлийг олгохЭзний өмнөөс гүйцэтгэж буй ажилд зайлшгүй гарах зарим задрдлыг олгох

Агентын бизнесийн гэрээ /ТОВА/

- Томилгоо хийх- Эзэн гэрээгээр агентыг өөрийн өмнөөс ажиллах зөвшөөрсөн зөвшөөрөл олгож томилох тухай
- Агентын хийхийг хориглосон үйлдлийг тодорхойлох тухай
- Зохих хуулийн нийцлийг хангаж ажиллах тухай
- Зуучлалын шимтгэлийг тохирох тухай
- Мэдээ, мэдээллийг авах, өгөх тухай
- Даатгалын хураамжийг хэрхэн удирдах тухай
- Даатгалын тохиолдлыг агентаар дамжуулан мэдэгдэх тухай
- Гэрээг цуцлах тухай
- Даатгалын гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлэх тухай
- Шүүх, хуулийн зохицуулалт ашиглах тухай
- Нууц хадгалах тухай
- Нөхөн олговор шаардах нөхцөл оруулах тухай
- Гэрээг баталгаажуулах тухай

2.5. Даатгуулах сонирхлыг тодорхойлох нь

- ✓ Даатгуулах сонирхол гэж юу вэ?
- ✓ Даатгуулах сонирхол хэрхэн бий болдог вэ?
- ✓ Даатгалын төрөл бүрт даатгуулах сонирхлыг хэзээ тодорхойлох вэ?

Даатгуулах сонирхол гэж юу вэ?

- Даатгуулах хууль ёсны эрх
- Хуулийн дагуу үүсч буй санхүүгийн хамаарлаас үүдэн гарч ирдэг
- Даатгуулагч этгээд болон даатгалын зүйлийн хооронд үүсч буй сонирхол

Даатгалын зүйл	Даатгалын гэрээнд даатгуулсан зүйл буюу жишээ нь бүх төрлийн хөрөнгийг хэлж болно. Даатгуулагчтай тухайн зүйл нь хуулийн хамааралтай байна. Жишээ нь: хөрөнгийн эзэн хөрөнгөө даатгуулах
	Даатгуулагч тухайн даатгуулсан хөрөнгөтэй санхүүгийн ашиг сонирхолтой байж болно. Жишээ нь: банк зээлийн барьцаанд байгаа хөрөнгийг даатгуулах
Хуулийн дагуу хамааралтай байх	Даатгуулагч, даатгалын зүйлийн хооронд хуулийн хамаарал байхгүй тохиолдолд даатгалын сонирхол үүсэхгүй гэж үзэх бөгөөд үүнийг хууль бусаар ашиг хонжоо хайж байгаа гэж үздэг.
Санхүүгийн үнэ цэнэтэй байх	Даатгалын зүйл нь санхүүгийн үнэ цэнэтэй байх ёстой.
Даатгалын сонирхол урьдчилан бий болох	Ирээдүйд өвлөж ирэх хөрөнгийг одоо даатгуулах боломжгүй буюу хууль ёсны дагуу өөрийн нэр дээр ирсэн хөрөнгөд даатгуулах сонирхол бий болно.

Даатгуулах сонирхол хэрхэн бий болдог вэ?

- ✓ Хуулийн дагуу буюу ямар нэгэн хөрөнгө эзэмшдэг байх үед хөрөнгөө хамгаалах зорилгоор даатгуулах сонирхол үүснэ.
- ✓ Бид хэн нэгэнд хохирол учруулах үед хуулийн дагуу хохирсон талын хохирлыг барагдуулах санхүүгийн шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд хариуцлагаа даатгуулах сонирхол үүсэх юм.
- ✓ Аливаа гэрээ байгуулсанаар бид тодорхой үүрэг хүлээдэг ба уг хүлээсэн үүргийн дагуу даатгуулах сонирхол үүсч болно. Жишээ нь хөрөнгийг түрээсэлж буй этгээд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах үүрэг хүлээсэн бол энэ тохиолдолд түрээслэгч тал хөрөнгийг даатгуулах сонирхол үүснэ.
- ✓ Тодорхой зарим хуулийн зохицуулалтын дагуу даатгуулах сонирол үүсч болно. Жишээ нь заавал даатгалтай байх ёстой хуулийн шаардлагууд гэх мэт.

Даатгалын гэрээг удирдах суурь зарчмуудыг мэдэх

Даатгалын төрөл бүрт даатгуулах сонирхлыг хэзээ тодорхойлох вэ?

	Амьдралын даатгал	Далайн тээврийн даатгал	Хөрөнгө болон Хариуцлагын даатгал
Даатгалын гэрээ эхлэх үед	Даатгуулах сонирхол байх ёстой	Шаардлагагүй	Даатгуулах сонирхол байх ёстой
Даатгалын тохиолдол болох үед	Шаардлагагүй	Даатгуулах сонирхол байх ёстой	Даатгуулах сонирхол байх ёстой

2.6. Даатгалын гэрээний дагуу мэдээллийг бүрэн зөв мэдүүлж танилцуулах зарчмын тухай

✓ Чин шудрагаар хандах зарчим /Principle of good faith/

Гэрээнд оролцож буй талууд холбоотой хамаарал бүхий мэдээллийг хэлцлийн явцад ил тод, үнэн зөв, шудрагаар гаргаж ил болгох үүрэгтэй.

✓ Мэдээллийг ил тод , үнэн зөвөөр мэдээллэх үүрэг /Duty of disclosure/

Хэрэглэгчийн Даатгалын Хууль
(мэдээллэх, танилцуулах тухай)
2012

The Consumer Insurance
(Disclosure and Representations)
Act 2012

- Уг хуулийн дагуу даатгуулахаар хүсэлт гаргаж буй хүн даатгагчид худлаа, ташуу мэдээлэл гаргаж өгөхгүй байхаар анхаарал хандуулах үүрэгтэй гэж заасан байдаг.
- Худлаа ташуу мэдээлэл гаргах гэдэг нь даатгал хүчин төгөлдөр болохоос өмнө даатгагчид үнэн бодит зүйлийг хэлэхгүй байх, өөр утга агуулгаар хэлэх ба үүнээс үүдэн даатгагч эрсдэлийг буруу үнэлж даатгах зэрэг алдаа гарч болно.

Даатгалын Хууль 2015
The Insurance Act 2015

- Уг хуулийн дагуу байгууллагын даатгалын харилцагч нь даатгагчид мэдэж байгаа болон мэдэх ёстой бүх мэдээллийг нэгтгэн цэгцтэй, ойлгомжтой байдлаар танилцуулах ёстой.
- Даатгагчийн хүсэлтийн дагуу нэмэлт шаардлагатай мэдээллийг хангалттай хэмжээнд гаргаж өгөх үүрэгтэй.
- Дээрх бүх мэдээлэл нь даатгуулагчийн удирдах түвшний менежерүүд мэддэг байх мэдээлэл байна.

Холбогдох мэдээлэл гэж юу вэ?

Холбогдох мэдээлэл /relevant information/ гэдэг нь:

- Даатгал хийх явцад Даатгагчийн мэдэх шаардлагатай тухайн даатгалд хамаарах ердийн мэдээллүүд
- Даатгуулагчид өөрт байгаа мэдээллүүд
- Даатгуулагчийн брокерт байгаа даатгуулагчийн тухай мэдээллүүд

Хөрөнгийн даатгал	<ul style="list-style-type: none">• Барилгын бүтэц, хийц• Барилгын материал• Галын аюулгүйн систем• Дулааны, цахилгааны систем
Тээврийн хэрэгслийн даатгал	<ul style="list-style-type: none">• Автомашины төрөл, насжилт• Жолоочийн нас• Жолооны үнэмлэх хүчин төгөлдөр эсэх• Өмнөх ослын түүхүүд• Автомашинаа хаана зогсоолд байршуулдаг• Автомашин юунд ихэвчлэн ашигладаг
Хулгайн эрсдэлийн даатгал	<ul style="list-style-type: none">• Бараа материалын төрөл, шинж чанар• Бараа материалын өртөг• Хамгаалалтын систем

Даатгалуулсан түүх	Өмнө нь даатгахаас татгалзаж байсан түүх байгаа эсэх, Хохирлын түүх
Хувь хүний түүх	Гэмт хэрэгт холбогдож байсан эсэх Хөрөнгийн менежментийг муу хийж байсан түүх Хайнга санаатайгаар хохирол учруулж байсан түүх

Мэдээллийг үнэн зөв, ил тод мэдээллээгүй тохиолдолд үүсэх үр дагаварууд



Жишээ:

- Даатгуулагчийн эхнэрийн нас 40 боловч, андуурч 39 настай гэж мэдэгдсэн.

Энэ тохиолдолд андуурч хэлсэн мэдээлэл нь эрсдэлд нөлөө үзүүлэхүйц биш тул гэм хоргүй алдаа гэж үзнэ.


- Даатгуулагч эрүүл мэндийн даатгал авахдаа хууч өвчинтэй тухайгаа асуулгын хуудас дээрээ дурдаагүй ба даатгалын нөхөн төлбөр авахаар хандах үед даатгагч энэ тухай олж мэднэ.

Энэ тохиолдолд даатгуулагч хэрвээ асуулгын хуудас дээр хууч өвчний тухай мэдээллээ оруулсан бол даатгагч уг өвчинтэй холбоотой нөхөн төлбөрийг төлөхгүй байх нөхцөлтэй хамгаалалт санал болгох байсан. Ийм учраас даатгагч дээрх нөхөн төлбөрт татгалзах ба өөр бусад өвчинтэй холбоотой нөхөн төлбөрийг төлнө.

- Даатгуулагч тээврийн хэрэгслийн даатгал авахдаа өмнө үүссэн байсан эвдрэлийг нуусан, жолоодох эрхээ хасуулсан мэдээллээ мөн адил мэдэгдэлгүй даатгуулсан.

Энэ тохиолдол нь санаатайгаар мэдээллийг нуусан гэж үзэн даатгагч гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх эрхтэй.

2.7. Анхдагч шалтгааны тайлбар ба үүнийг нөхөн төлбөрт хэрхэн авч үзэх тухай



“Шүдэнз асаасан” - анхдагч шалтгаан

Хохирол үүсгэсэн шалтгаануудаас давамгайл нөлөө үзүүлсэн, хохирол гарахад шууд хамааралтай байх шалтгааныг анхдагч шалтгаан гэж үзнэ.

2.7. Анхдагч шалтгааны тайлбар ба үүнийг нөхөн төлбөрт хэрхэн авч үзэх тухай

Хохирлын анхдагч шалтгаан нь доор дурдсан 3 ангилалын аль хэсэгт хамаарч байгаагаас үндэслэн Даатгагч нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.

- **Даатгагдсан эрсдэл /insured perils/** – хохирлын анхдагч шалтгаан нь энэ бүлэгт багтвал даатгал үйлчилнэ
- **Хасагдсан эрсдэл /excepted or excluded perils/** – хохирлын анхдагч шалтгаан энэ бүлэгт багтвал даатгал үйлчлэхгүй
- **Дурдагдаагүй эрсдэл /uninsured or unnamed perils/**– хохирлын шалтгаан энэ бүлэгт багтсан тохиолдолд хохирлыг үүсгэхэд нөлөөлсөн шалтгааны давамгайлал шалтгаан нь даатгагдсан бол даатгал үйлчилнэ, хэрвээ хасагдах бүлэгт багтвал даатгал үйлчлэхгүй

Анхдагч шалтгааныг даатгалын гэрээнд өөр өөрөөр тодорхойлж болдог. Жишээ нь бидний түгээмэл ашигладаг нэрлэсэн эрсдэл бүхий даатгалын гэрээнүүдийн эрсдэлийн хэсэгт дурдсан эрсдэлүүд юм.

2.8. Нөхөн төлбөр олгох зарчмууд ба даатгалын гэрээнд тусгагдах тухай

Нөхөн төлбөр гэдэг нь хохирлын дараа хурдан хугацаанд өмнө байсантай ижил санхүүгийн түвшинд даатгуулагчийг аваачих зорилготой хохирлыг барагдуулах санхүүгийн төлбөр юм.

Даатгалын ихэнх гэрээ нь нөхөн төлбөр олгох /indemnity/ гэрээ байдаг боловч зарим даатгалын төрөл нь санхүүгийн тэтгэмж олгох зорилготой даатгалууд байдаг. Үүнд:

- Гэнэтийн ослын даатгал
- Өвчний даатгал
- Хурч өвчний даатгал
- Богино хугацааны орлого тасалдлын даатгал /хувь хүн/ гэх мэт.

Нөхөн төлбөр олгох хэлбэрүүд

Аль ч төрлийн хөрөнгийн даатгал нь хөрөнгөд учирсан хохирлыг даатгалын гэрээнд заасан үнэлгээнд багтаан нөхөн төлбөрийг олгох ба дараах 4 өөр төрлийн нөхөн олгох хэлбэрийн аль нэгийг баримталж олгох тухай заасан байдаг. Хэрвээ даатгалын гэрээнд нөхөн олгох хэлбэрийг дурдаагүй тохиолдолд даатгуулагч хохирлоо барагдуулах санхүүгийн нөхөн олговор авах хуулийн эрхтэй байдаг.

- **Мөнгөн хэлбэрээр олгох /cash payment/** – нөхөн төлбөрийг даатгагчаас даатгуулагчид мөнгөөр төлөх
- **Засах /repair/** – гэмтсэн хэсгийг засуулах сонголтыг олгох ба засуулах хэлбэр нь даатгагч засварын газруудтай гэрээлж хөнгөлттэй үнээр, баталгаат засварыг даатгуулагчид хүргэснээр нөхөн төлбөрийн зардлыг бууруулах, харилцагчаа хадгалах давуу талыг олгодог.

Нөхөн төлбөр олгох хэлбэрүүд

- **Орлуулах /replacement/** – Энэ хэлбэр нь орон сууцны даатгалд илүү ашигладаг ба жижиг хэмжээний хохирлыг даатгагчийн хамтын ажиллагаатай дэлгүүр, борлуулагчаас шинээр авах, солиулах хэлбэр юм. Орлуулах хэлбэрээр нөхөн төлбөр тооцох нь дараах давуу талуудыг даатгагчид олгодог:

Хөнгөлттэй үнэ нь нөхөн төлбөрийн зардлыг буруулах

Бэлэн мөнгөөр нөхөн төлбөр олголгүй оруулах хэлбэрээр олгох нь хуурамч нөхөн төлбөр авах боломжийг бууруулах

Харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

- **Сэргээн босгох /reinstatement/** – Байшин, барилга, суурин машин төхөөрөмжийг хохирлоос өмнөх хэлбэрт буцаан сэргээх ажлыг даатгагч гүйцэтгэдэг.

Хөрөнгийн даатгалын нөхөн төлбөрийг хэрхэн тооцох вэ?

Энгийн хамгаалалт	<ul style="list-style-type: none">• Даатгагч тохиолдол болсон үеийн хөрөнгийг засах, дахин босгох зардлаар нөхөн төлбөрийг тооцно.• Энэ тохиолдолд барилгыг засах, дахин босгох үед барилгад өмнөхөөсөө илүү сайжруулалт бий болно гэж үзэх ба үүнийг даатгагч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болдог.• Барилга байгууламжийн даатгалыг энэ нөхцөлөөр даатгах нь маш ховор байдаг.
Сэргээн босгох хэлбэрээр нөхөн төлбөр тооцох нөхцөл	<ul style="list-style-type: none">• Хөрөнгийн даатгалын үнэлгээг дахин сэргээн босгоход шаардлагатай нийт зардлын үнэлгээгээр тооцдог ба үүнд ямар нэгэн элэгдэл хорогдлын зардлыг тооцохгүй.• Даатгалын үнэлгээ нь одоогийн бодит үнэлгээний 85%-с багагүй байх ёстой• Сэргээн босгох ажил нь ямар нэгэн саатал, хоцрогдолгүйгээр шууд хийгдэх ёстой ба даатгуулагч дахин сэргээн босгох ажлыг гүйцэтгүүлэхэд уян хатан хандах шаардлагатай болдог.
Day One reinstatement	<ul style="list-style-type: none">• Энэ нөхцөл нь даатгуулагч даатгалын хамгаалалт авах эхний өдрийн үеийн дахин сэргээн босгох нийт үнийг даатгагчид мэдэгдэх ёстой• Даатгагч мэдүүлсэн үнэлгээг 50%-р нэмэгдүүлсэн тэнцэх хэмжээтэйгээр инфляцын нөлөөллийг зөвшөөрөх ба үүний төлөө хураамж дээр 15%-н нэмэгдлийг нэмж тооцно.
Сэргээн босгох нөхцөлөөр тооцон бэлэн мөнгө хэлбэрээр нөхөн төлбөр олгох	<ul style="list-style-type: none">• Сэргээн босгох нөхцөл бүрэн хэрэгжих боломжгүй бол сэргээн босгох нөхцөлөөр тооцсон дүнгээс элэгдэл хорогдлыг хасч нөхөн төлбөрийг бэлэн мөнгө хэлбэрээр олгодог.

Бараа материалын нөхөн төлбөрийг хэрхэн тооцох вэ?

<p>Үйлдвэрлэгчийн бараа материал</p>	<ul style="list-style-type: none">• Энэ төрлийн бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн зэргээс бүрддэг• Иймд нөхөн төлбөрийн үнэлгээг тооцохдоо даатгалын тохиолдол болсон үеийн түүхий эд материалын зардал дээр дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүнтэй холбогдон гарсан хөдөлмөрийн зардал, тээврийн зардлыг нэмж тооцдог.
<p>Худалдан борлуулагчийн бараа материал</p>	<ul style="list-style-type: none">• Худалдан борлуулж буй бараа бүтээгдэхүүний нөхөн төлбөрийн үнэлгээг тооцохдоо даатгалын тохиолдол болсон үеийн тухайн бараа бүтээгдэхүүнийг орлуулах зардал дээр тээвэр, сав баглаа боодлын зардлыг нэмж тооцдог.

Бараа материалын нөхөн төлбөрийг тооцоход тухайн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулсанаас үүсэх ашгийг оруулдаггүй. Энэ төрлийн нөхөн төлбөрийг олгох зорилготой даатгал нь бизнес тасалдлын даатгал байдаг.

Хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийг хэрхэн тооцох вэ?

1. Тохиролцсон үнэлгээ бүхий даатгалын гэрээ / Agreed value policies/

Энэ нөхцөлтэй гэрээ нь даатгалын гэрээ эхлэх үед даатгалын үнэлгээг харилцан тохиролцдог ба энэ үнэлгээг даатгалын гэрээний туршид хэвээр хадгална. Даатгалын тохиолдол болсон үед даатгалын үнэлгээг бодит зөв байсан эсэхийг батлах шаардлагагүй юм.

Энэхүү нөхцөлөөр дараах төрлийн даатгалуудыг хийдэг:

- Далайн тээврийн даатгал
- Уран зураг, үнэт эдлэлийн даатгал
- Ховор содон автомашины даатгал

2. First Loss даатгалын гэрээ

Даатгуулагч зарим шалгтаан нөхцөлийн улмаас даатгуулж буй хөрөнгөд бүрэн хохирол учрахгүй, харин хэсэгчилсэн хохирлууд илүү тохиолдох магадлалтай гэж үзсэн тохиолдолд энэхүү даатгалын нөхцөлөөр гэрээг хийдэг. Даатгуулагч даатгалын үнэлгээг мэдүүлэхдээ бодит бүрэн үнэлгээгээс багаар мэдүүлж даатгалын үнэлгээг тогтооно.

Энэ тохиолдолд даатгагч хураамжийг бүтэн үнэлгээнээс тооцох ба үүнээс хөнгөлөлтийг хасч тооцно. Учир нь даатгагч бүтэн үнэлгээний эрсдэлийг бичилгүй багасгасан үнэлгээгээр тооцож даатгасан ба уг бичигдсэн үнэлгээ хүртэл нөхөн төлбөр олгох юм. Нөхөн төлбөрийг тооцохдоо аливаа дундаж тооцохгүй.

2.9. Дутуу даатгуулах, дундаж тооцох, хариуцах хэсгийн тухай

<p>▪ Дутуу даатгуулах / Underinsurance</p>	<p>▪ Дундаж тооцох / Average</p>	<p>▪ Хариуцах хэсэг / Excess</p>
<p>Эрсдэлийн санд нэгдэх гол зарчим нь зөв тохирсон хураамжийг төлөх буюу даатгуулагч өөрийн хөрөнгийн дахин сэргээн босгоход шаардагдах бүтэн үнэлгээг даатгуулахдаа мэдэгдэж даатгуулах нь зөв хураамжийг тооцох үндэс болдог. Хэрвээ даатгуулагч үнэлгээг багаар тооцон бага хэмжээний хураамж төлсөн бол үүнийг эрсдэлийн санд оруулж буй хувь оролцоо шудрага бус гэж үзэх юм.</p>	<p>Даатгуулагч хөрөнгийн үнэлгээг бодитоор бүрэн мэдүүлэлгүй дутуу даатгуулсан тохиолдолд нөхөн төлбөрийг олгохдоо дундаж тооцох буюу хувь тэнцүүлэн тооцно. Дундаж тооцох нөхцөл нь зөвхөн хөрөнгийн даатгалд хамаарах ба хариуцлагын даатгалд уг нөхцөлийг ашигладаггүй.</p>	<p>Хариуцах хэсэг нь:</p> <ul style="list-style-type: none"> • Заавал буюу даатгагчаас зайлшгүй шаардаж буй нөхцөл • Сайн дурын буюу даатгуулагч даатгалын хураамжийг буулгах зорилгоор нэмэлтээр оруулж буй гэсэн хоёр хувилбартай байж болно. <p>Excess – ихэвчлэн иргэдийн даатгалын гэрээний нөхцөл дурдагддаг ба бага хэмжээний өөрийн хариуцах хэсэг юм.</p> <p>Deductible – арилжааны даатгалд хэрэглэдэг ба өндөр хэмжээний өөрийн хариуцах хэсгийг хэлдэг.</p>

2.10. Давхардсан даатгалыг зохицуулах, даатгагч нарын оролцоо

1. Даатгуулагч хоёр ба түүнээс олон хүчин төгөлдөр даатгалтай бол яах вэ?
2. Даатгуулагч нэг тохиолдолд даатгалын гэрээ бүрээс нөхөн төлбөр авч болох уу?
3. Олон даатгалтай байснаар бодит учирсан хохирлын дүнгээс илүү хэмжээний нөхөн төлбөр авч болох уу?

2.10. Давхардсан даатгалыг зохицуулах, даатгагч нарын оролцоо

Жишээ:

Даатгуулагч нийт 200 сая төгрөгийн үнэлгээтэй орон сууц болон доторх эд зүйлсээ хөрөнгийн даатгалаар А даатгалын гэрээ. Үүний дараа орон сууцны үнэ өсч 300 сая төгрөг болох үед Б даатгагчид үнэлгээг 100 сая төгрөгөөр нэмэгдүүлэн даатгуулсан.

Галын эрсдэл учирч даатгуулагчид 240 сая төгрөгийн хохирол үүсэхэд даатгагч тус бүр өөрийн хувь оролцоогоор хохирлыг хариуцна. А даатгагч 160 сая төгрөг, Б даатгагч 80 сая төгрөгийн нөхөн төлбөр олгох буюу даатгуулагч нь учирсан хохирлын дүнгээс давуулан нөхөн төлбөр авахгүй.

2.10. Давхардсан даатгалыг зохицуулах, даатгагч нарын оролцоо

Давхардсан даатгалын зохицуулах нөхцөл хэрэгжих шаардлага буюу юунаас шалтгаалан үүсдэг вэ?

- 2 ба түнээс дээш даатгалын гэрээ хүчинтэй байх
- Даатгалын гэрээнүүдэд ижил даатгуулах сонирхол оршиж байх
- Даатгалын гэрээнүүд ижил эрсдэлээс хамгаалсан байх
- Даатгалын гэрээний зүйл нэг ижил байх
- Даатгалын гэрээ бүр тухайн хохиролд хариуцлага хүлээхээр байх
- Аль ч даатгалын гэрээ давхардсан даатгалыг хэрхэн зохицуулах тухай нөхцөлийг дурдаагүй, оруулаагүй байх

2.11. Буцаан нэхэмжлэх эрхийн тухай зарчмууд

Буцаан нэхэмжлэх эрх нь дараах нөхцөл нь дараах хэлбэрээр үүсдэг:

- Гэм хорын хариуцлага
- Гэрээний зөрчил

2.11. Буцаан нэхэмжлэх эрхийн тухай зарчмууд

Гэм хорын хариуцлага

Хүн бүр хийж буй үйлдэлдээ бусдын өмнө үүрэг, хариуцлага хүлээдэг. Энэхүү үүрэг, хариуцлагаа зөрчсөн бол үүнийг гэм хорын хариуцлага хүлээх нөхцөл үүсэх ба хохирсон этгээд нөхөн төлбөр нэхэмжилдэг.

Жишээ:

Таны машиныг мөргөж гэмтээсэн тохиолдол үүссэн. Та засварын зардлаас гадна засварт байх хугацаанд ажлаа хийхийн тулд өөр машин түр хугацаанд түрээслэж унасан зардал гаргасан боловч даатгагч зөвхөн машины зардлыг нөхөн төлсөн бөгөөд хохирлыг буцаан нэхэмжлэхдээ зөвхөн засварын зардлыг буцаан нэхэмжилсэн.

Буруутай этгээд нэг тохиолдолд зөвхөн нэг удаа хариуцлагад татагдах тул энэ тохиолдолд машин түрээслэсэн зардал буюу дурдагдаагүй эрсдэлийн улмаас үүссэн хохирлыг хэн хариуцах вэ?

Энэ тохиолдолд даатгагч нь хохирогч буюу даатгуулагчийн нэрийн өмнөөс хариуцлага нэхэх тул хохирогчид нэмэлтээр бий болсон машин түрээсийн зардлыг засварын зардлын хамт буруутай этгээдээс нэхэжилнэ. Иймд нийтлэг практикт дурдагдаагүй эрсдэлээс бий болсон хохирлыг даатгагч төлөх ба үүнийгээ буруутай этгээдээс нэхэмжилнэ.

2.11. Буцаан нэхэмжлэх эрхийн тухай зарчмууд

Гэрээний зөрчил

Аливаа гэрээгээр зөрчил үүссэн тохиолдолд буруутай эсэхээс үл хамааран хохирлыг барагдуулах шаардлага үүсдэг. Даатгагч үүнээс буцаан нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлэх боломжтой юм.

Жишээ:

T нь байр түрээслэх гэрээтэй ба T болон хөрөнгийн эзний хооронд байгуулсан түрээсийн гэрээнд хөрөнгөд аливаа хохирол учирвал T нь хариуцлага хүлээнэ гэж заажээ. Иймд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд хөрөнгийн эзэн өөрийн хөрөнгийн даатгалаар уг хохирлоо барагдуулах ба харин даатгагч түрээсийн гэрээний дагуу T-ээс буцаан нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлж олгосон нөхөн төлбөрөө нэхэмжлэх юм.

Ихэвчлэн барилгын төслүүдэд захиалагч, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нарын гэрээнд хууль болон даатгалын үүрэг хариуцлагын талаар тодорхой зааж оруулсан байдаг.

2.11. Буцаан нэхэмжлэх эрхийн тухай зарчмууд

Гэрээний зөрчил

Аливаа гэрээгээр зөрчил үүссэн тохиолдолд буруутай эсэхээс үл хамааран хохирлыг барагдуулах шаардлага үүсдэг. Даатгагч үүнээс буцаан нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлэх боломжтой юм.

Жишээ:

T нь байр түрээслэх гэрээтэй ба T болон хөрөнгийн эзний хооронд байгуулсан түрээсийн гэрээнд хөрөнгөд аливаа хохирол учирвал T нь хариуцлага хүлээнэ гэж заажээ. Иймд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд хөрөнгийн эзэн өөрийн хөрөнгийн даатгалаар уг хохирлоо барагдуулах ба харин даатгагч түрээсийн гэрээний дагуу T-ээс буцаан нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлж олгосон нөхөн төлбөрөө нэхэмжлэх юм.

Ихэвчлэн барилгын төслүүдэд захиалагч, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нарын гэрээнд хууль болон даатгалын үүрэг хариуцлагын талаар тодорхой зааж оруулсан байдаг.

2.11. Буцаан нэхэмжлэх эрхийн тухай зарчмууд

Буцаан нэхэмжлэх эрх хэрэгжихгүй байх нөхцөлүүд:

- Даатгуулагч буруутай этгээдээс гэм хор шаардах эрхгүй байх /hold harmless agreement/ нөхцөлтэй гэрээтэй тохиолдолд даатгагч буцаан нэхэмжлэх эрх хэрэгжүүлэх боломжгүй болно
- Benefit policies буюу тэтгэмж олгох зорилготой гэнэтийн осол, өвчлөл, амь нас гэх мэт даатгалд даатгагч буцаан нэхэмжлэх эрх хэрэгжүүлдэггүй.
- Даатгалын гэрээнд буцаан нэхэмжлэх эрхээс татгалзсан нөхцөлтэй тохиолдол. Ихэвчлэн нэг толгойтой групп компаниуд хоорондоо буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар нөхцөлтэй даатгалын гэрээ хийдэг.
- Түнш хамтрагч /negligent fellow worker/ нь буруутай тохиолдолд түүнээс буцаан нэхэмжлэх эрх үүсэхгүй.

3. Даатгалын салбарын бүтцийг таньж мэдэх

- 3.1. Даатгалын салбарыг бүрдүүлж буй оролцогчид
- 3.2. Даатгагч, давхар даатгагч ба Lloyd's-н тухай, даатгалын салбарын мэргэжилтнүүд
- 3.3. Даатгалын бүтээгдэхүүний төрлүүд
- 3.4. Даатгалын бүтээгдэхүүн борлуулах сувгуудын тухай, тэдгээрийн онцлог

3.1. Даатгалын салбарыг бүрдүүлж буй оролцогчид

Худалдан авагчийн төрөл:

- Хувь хүмүүс
- Аж ахуй нэгж байгууллагууд
- Төрийн байгууллагууд
- Төрийн бус байгууллагууд

Худалдагч буюу даатгагчийн төрөл:


- Хязгаарлагдмал хариуцлагат буюу хувийн өмчийн компани
- Mutual буюу Хамтын сан хэлбэрийн компаниуд
- Protection and indemnity (P&I) clubs буюу Ашгийн бус холбоод
- Captive insurers
- Composite companies буюу урт хугацааны даатгал болон арилжааны даатгал аль алийг бичдэг даатгагч
- Тусгайлсан нэг төрлийн даатгал бичдэг даатгагчид / takaful insurance companies/

3.2. Даатгагч, давхар даатгагч ба Lloyd's-н тухай, даатгалын салбарын мэргэжилтнүүд

Даатгалын зах нь дараах 5 үндсэн бүрэлдэхүүн хэсгээс тогтдог:

- Худалдан авагч
- Даатагч буюу худалдагч
- Дундын зууч
- Aggregators буюу даатгалын үнийг харьцуулах веб хуудас
- Давхар даатгагч

Мэдээллийн урсгал:



Олон улсын даатгагч нарын
ЖИШЭЭ:

Эх сурвалж: asianinsurancereview.com

<input type="checkbox"/> Company <input type="checkbox"/>	Classification	Country
<input type="checkbox"/> AIA Singapore Private Limited	Composite Insurer	Singapore
<input type="checkbox"/> AIG Asia Pacific Insurance Pte Ltd	General Insurer	Singapore
<input type="checkbox"/> Allianz Global Corporate & Specialty SE, Singapore Branch (Allianz Commercial)	General Insurer	Singapore
<input type="checkbox"/> Allianz Insurance Singapore Pte Ltd	Composite Insurer	Singapore
<input type="checkbox"/> Allianz SE Reinsurance Branch Asia Pacific	Composite Reinsurer	Singapore
<input type="checkbox"/> Allied World Assurance Company Ltd (Singapore Branch)	General Insurer & Reinsurer	Singapore
<input type="checkbox"/> Allied World Syndicate Services (Singapore) Pte Ltd	Lloyd's Syndicate	Singapore
<input type="checkbox"/> Antares Underwriting Asia Pte Limited	Lloyd's Syndicate	Singapore
<input type="checkbox"/> Asia Pacific Financial Services Association (APFinSA)	Association	Singapore
<input type="checkbox"/> Aspen Bermuda Limited Singapore Branch (Aspen Re)	General Reinsurer	Singapore
<input type="checkbox"/> Assuranceforeningen Skuld (Gjensidig) Singapore Branch	P & I Clubs	Singapore
<input type="checkbox"/> Asta Solutions Asia Pte Ltd	Lloyd's Syndicate	Singapore
<input type="checkbox"/> Atradius Credito y Caucion S.A. de Seguros y Reaseguros	Credit Insurer	Singapore
<input type="checkbox"/> Auto & General Insurance (Singapore) Pte Ltd (trading as Budget Direct Insurance)	General Insurer	Singapore
<input type="checkbox"/> AXA XL, Catlin Re Switzerland Ltd (Singapore Branch)	General Reinsurer	Singapore

Lloyd's

Lloyd's нь даатгалын эрсдэлийн арилжаа явагддаг дэлхий дээрх хамгийн том даатгалын зах юм.

Lloyd's синдикатууд нь эрсдэлийг даах санхүүгийн чадамжтай хувь хүмүүс болон байгууллагуудын нэгдэл байдаг.


Синдикат бүр өөрийн өмнөөс эрсдэлийг бичих үйл ажиллагааг авч явах үйл ажиллагааны агентийг томилж ажлуулдаг бөгөөд тэдний гол үүрэг нь эрсдэлийг бичих андеррайтер юм.

Үй ажиллагааны агент нь ихэвчлэн байгууллага байдаг ба хэд хэдэн синдикатуудын өмнөөс ажиллаж болдог.

2022 оны жилийн эцсийн байдлаарх Lloyd's –н мэдээллээр:

Үйл ажиллагааны агент буюу managing agents 52

Синдикатууд 77 байсан.



Lloyd's дээр гүйлгээ хэрхэн хийгддэг вэ?

Lloyd's дээр гүйлгээ хийхийн тулд бүртгэлтэй брокеруудаар дамжих ёстой бөгөөд Market Reform Contract /slip/ гэх нэгдсэн нарийн дэг журамтай байршуулалтын бичиг баримтыг ашиглаж байршуулалт хийгддэг.

Брокерууд үнийн санал өгсөн андеррайтертай хамгийн түрүүнд тухайн эрсдэл дээр орох хувь хэмжээ, нөхцөлийг тохиролцдог ба түүний ардаас орж ирэх андеррайтерууд тохиролцож слип дээр гарын үсэг баталгаажуулалтыг хийдэг. Ингэснээр нийт хувь 100% болоход эрсдэл бүрэн байршсан гэж үздэг.

Брокерууд даатгалын слипийг эцсийн байдлаар бэлтгэн шалгаж дуусах ба үүнийг Lloyd's дотоодын Xchanging Ins-sure Services нэгдсэн систем дээр байршуулж баталгаажуулалт хийнэ.

Брокерууд нь хураамжийг цуглуулж авах ба өөрийн шимтгэлийг хасч андеррайтер тус бүр рүү ногдох цэвэр хураамжийг шилжүүлдэг.

Синдикатууд захиалгын арга дээр суурилж нэг эрсдэлийг хуваан бичих нь синдикатуудын хамтрал, уян хатан үйлчилгээ үзүүлэх, сонголтыг бий болгох зэрэг давуу байдлыг бий болгодог ба энэ нь Lloyd's-г дэлхийн тэргүүлэх даатгалын платформ болгож байгаа юм.

Давхар даатгал орших үндэс:

- ✓ Нөхөн төлбөр тогтвортой байх
- ✓ Санхүүгийн тогтвортой байдал
- ✓ Харилцагчийн үйлчилгээг сайжруулах
- ✓ Даатгагчийг шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд дэмжлэг болох

Дундын зуучийн үзүүлэх үйлчилгээ:

- ✓ Эрсдэлийг хаана байршуулах шийдвэр гаргах
- ✓ Харилцагчийн хэрэгцээг тодорхойлж, эрсдэлийг танилцуулах
- ✓ Даатгалын гэрээний эхэн болон дундуур шаардлагатай өөрчлөлтийг хийх, тохиролцох
- ✓ Харилцагчид даатгалын гэрээний нөхцөл, агуулгыг танилцуулах, зөвлөх
- ✓ Даатгалын сунгалтыг удирдах
- ✓ Нөхөн төлбөрийн явцад харилцагчид зөвлөх, дэмжлэг үзүүлэх
- ✓ Эрсдэлийн удирдлагын зөвлөгөө өгөх
- ✓ Даатгалын гэрээнд дурдагдаагүй эрсдэлээс үүдэн гарсан нөхөн төлбөрийг хэрхэн авах талаар зөвлөгөө өгөх

Даатгагчийн өмнөөс гэрээний тохиролцооны дагуу дараах үйлчилгээг үзүүлдэг:

- ✓ Хураамжийг цуглуулах
- ✓ Эрх олгосон бол даатгагчийн өмнөөс эрсдэлийг бичих
- ✓ Эрх олгосон тохиолдолд даатгагчийн өмнөөс нөхөн төлбөрийг шилжүүлэх
- ✓ Даатгасныг батлах баримт бичгийг үйлдэх

Даатгалын үйл ажиллагаанд оролцох мэргэжилтнүүд ба тэдгээрийн үүрэг

- ✓ Андеррайтерууд / Underwriters
- ✓ Нөхөн төлбөрийн мэргэжилтнүүд / Claim handlers
- ✓ Хохирол үнэлгээчид / Loss adjusters
- ✓ Нөхөн төлбөрийн зөвлөх / Loss assessors
- ✓ Актуарчид / Actuaries
- ✓ Эрсдэлийн менежер / Risk managers
- ✓ Дотоод аудитор / Internal auditors
- ✓ Нийцлийн мэргэжилтэн / Compliance officers

Андеррайтер

- Эрсдэлийн санд нэмэгдэж буй эрсдэлийг үнэлэх
- Эрсдэлийг бичих эсэхийг шийдэх
- Даатгалын нөхцөлийг тохиролцох
- Нөөц сан, учирч болох нөхөн төлбөрийн хэмжээ, холбогдох зардал, ашигт ажиллагаа зэргийг тооцон боломжит хураамжийг тооцох

Нөхөн төлбөрийн мэргэжилтэн

- Нөхөн төлбөр дээр хурдан, шудрагаар ажиллах
- Хуурамч нөхөн төлбөрийг ялгах
- Нөөц сан бүрдүүлэхэд нөхөн төлбөрийн зардлыг тооцох
- Хохирол үнэлгээчин болон бусад оролцогч талуудыг оролцуулах эсэхийг шийдэх
- Боломжит зардлаар нөхөн төлбөрийг шийдвэрлэх

Хохирол үнэлгээчин / Loss adjuster

Даатгагч өндөр дүн бүхий, нарийн төвөгтэй даатгал дээр хохирол үнэлгээчнийг өөрөө томилдог.

Хохирол үнэлгээчний гүйцэтгэх үүрэг:

- ✓ Хохирлыг шинжлэн судлах
- ✓ Даатгалын гэрээгээр тус хохирол нь төлөгдөх эсэхийг тодорхойлох
- ✓ Шаардлагатай тохиолдолд хохирлыг нэмж гаргуулахгүй байх арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх
- ✓ Нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох
- ✓ Шаардлагатай мэргэжилтнүүдийг ажлуулах
- ✓ Даатгагчид нөхөн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зөвлөмжийг бэлтгэх

Нөхөн төлбөрийн зөвлөх / Loss assessor

Нөхөн төлбөрийн зөвлөх нь даатгуулагчийн өмнөөс нөхөн төлбөрийн хэлэлцээрт орж ажилладаг биеэ даасан мэргэжилтэн юм. Ажлын хөлсийг даатгуулагч төлнө.

3.3. Даатгалын бүтээгдэхүүний ангилал

- ✓ Автотээврийн хэрэгслийн даатгал
- ✓ Орон байрны даатгал
- ✓ Гадаадад аялалын даатгал
- ✓ Тэжээвэр амьтны даатгал
- ✓ Эрүүл мэндийн даатгал
- ✓ Хариуцлагын даатгал
- ✓ Арилжааны зориулалтын буюу байгууллагын хөрөнгийн даатгал
- ✓ Санхүүгийн даатгал
- ✓ Инженерийн даатгалууд
- ✓ Далайн тээврийн даатгал
- ✓ Агаарын хөлгийн даатгал
- ✓ Багцалсан даатгал

Эрүүл мэндийн даатгалууд

Гэнэтийн ослын даатгал / personal accident cover	Хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдах, нас барах зэрэг ноцтой бэртэл гэмтлийн үед тогтмол мөнгөн дүнгээр нөхөн төлбөр олгоно
Өвчлөлийн даатгал / sickness cover	Аливаа өвчний улмаас ердийн ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй тохиолдолд даатгуулагийн нэг сарын цалингийн 50-70% хүртэл хэмжээнд хамгийн багадаа долоо хоногийн хугацаа ба түүнээс дээш хугацаанд төлөх даатгал юм
Эмчилгээний зардлын даатгал / medical insurance	Өвчтэй байх үеийн эмнэлэг эмчилгээний зардлыг төлнө
Богино хугацааны орлого тасалдлын даатгал / Short-term income protection	Даатгуулагч ослын бэртэл гэмтэл, өвчин, ажлаас халагдах зэргээр хэсэг хугацаанд орлого тасалдал үүсэхэд 12 сар хүртэл хугацаанд тохирсон дүнгээр сар бүр тэтгэмж олгох даатгал юм
Хурц өвчний даатгал / critical illness cover	Хурц өвчнөөр өвдсөн үед тогтмол дүнгээр нөхөн төлбөр олгох даатгал юм. Гол зорилго нь хурц өвчлөлөө үүдсэн санхүүгийн хүндрэлийг давахад туслах.

Хариуцлагын даатгалууд

Ажилтны тэтгэмжийн даатгал/ employees" compensation	Ажилтан ажлаа гүйцэтгэж байх үедээ гэмтэх бэртэх, хурц өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчин тусах, нас барах зэрэгт ажил олгогчийн ажилтны өмнө хуулиар хүлээсэн хариуцлагаа даатгуулж буй юм.
Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын даатгал/ Public liability	Даатгуулагч эсвэл даатгуулагчийн ажилтны хайнга байдлаас үүдэн бусад этгээдийн бие махбодид гэмтэл учруулах, хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд үүсэх нөхөн олговрыг даатгагч төлнө.
Бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлагын даатгал / Products liability	Борлуулж, нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс шалтгаалан бусад этгээдийн бие махбодид гэмтэл учруулах, хөрөнгөд хохирол учруулсан хуулийн хариуцлагыг даатгана
Удирдах ажилтны хариуцлагын даатгал / Directors' and officers' liability	Удирдах албан тушаалд байгаа хувь хүнийг ажил үүргийн хүрээнд алдаа гаргасан, хайнга хандсан, хуулийн дагуух үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйн улмаас санхүүгийн хохирол учирсан үед үүсэх хуулийн хариуцлагыг даатгана
Мэргэжлийн хариуцлагын даатгал/ Professional liability	Мэргэжлийн чадвар чадамжийн хүрээнд зөвлөх үйлчилгээ, үйлдэл үзүүлж байхдаа хайнга алдаа гаргасны улмаас бусдад хохирол учруулсан гэж үзэн эсрэг нэхэмжлэл гаргасан тохиолдолд даатгуулагчийг хамгаалах даатгал юм.


Санхүүгийн даатгалууд /pecuniary insurance/

Чин шудрагын баталгаа/ Fidelity guarantee	Ажилтан шудрага бус, итгэл алдсан үйлдэл гаргаж мөнгө, бараа материалын алдагдсанаас үүсэх санхүүгийн хохирлыг даатгах юм.
Хууль зүйн үйлчилгээний зардлын даатгал/ Legal expense insurance	Иргэний хэргийн шүүхэд хандах, дуудагдах үед хууль зүйн зөвлөгөө авахад шаардагдах зардлын даатгал юм.
Зээлийн даатгал / Credit insurance	Дараа төлөгдөх нөхцөлтэй бараа бүтээгдэхүүн нийлүүлсэний дараа худалдан авагч тал төлбөрийг төлөх боломжгүй болсон тохиолдолд худалдагч талд үүсэх санхүүгийн алдагдлыг нөхөх даатгал юм.
Бизнес тасалдлын даатгал / Business interruption insurance	Даатгуулагчийн хөрөнгөд хохирол учирсаны улмаас бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжгүй үед үүсэх орлогын тасалдлын даатгал ба орлого тасалдлыг тооцоходоо бизнесийн орчны нөлөөлөл, бизнесийг буцаан сэргээхэд шаардах нэмэлт ажиллах хүчний зардал зэргийг авч үздэг.
Улс төрийн эрсдэлийн даатгал/ Political risk insurance	Улс төрийн эргэлт, бусад улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан бизнест хохирол учирсан тохиолдолд үйлчлэх даатгал юм.

Инженерийн даатгалууд /engineering insurance/

Гүйцэтгэгчийн бүх эрсдэлийн даатгал / Contractor's all risks	Барилгын том төслүүдэд уг даатгалыг шаарддаг буюу төслийн хугацаанд төсөл дээр ажиллаж байгаа гүйцэтгэгч нар, ажилчдын эсрэг үүсч болох хөрөнгө, материалд учирч болох бүх эрсдэлээс хамгаалах юм.
Угсралтын үеийн бүх эрсдэлийн даатгал/ Erection all risks (EAR)	Энэ даатгал нь суурин тоног төхөөрөмж, байгууламжийг суурилуулах үеийн эрсдэлээс хамгаалах даатгал юм.
Тоног төхөөрөмжийн эвдрэлийн даатгал / Machinery breakdown	Бойлер, хийн даралтад сав, хөдөлгүүрт, цахилгаан тоног төхөөрөмж, өргөгч машин гэх мэт өөр бусад компьютер тоног төхөөрөмжид урьдчилан тооцоолоогүй, хараагүй гэнэтийн гэмтэл гарах, ажиллахгүй зогсох үед уг даатгал үйлчилнэ.
Бойлер тэсрэх дэлбэрэх эрсдэлийн даатгал/ Boiler explosion	Бойлер, даралтат сав ердийн ажиллаж байх үедээ гэнэтийн дэлбэрэлт тэсрэлт болоход уг даатгал үйлчилнэ. Уг даатгал нь өөрт учирсан хохирлоос гадна бусад этгээдэд учирсан хохирлыг мөн хамгаалах зорилготой.

3.4. Даатгалын бүтээгдэхүүн борлуулах сувгуудын тухай, тэдгээрийн онцлог



4. Даатгалын бизнес явуулахтай холбоотой үндсэн зохицуулалтууд, хуулийн зарчмууд

4.1. Даатгалын салбарын зохицуулалтын ач холбогдол

4.2. Даатгагчийн хөрөнгийн хүрэлцээтэй байдал

4.3. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ба луйвар хэрхэн даатгалын салбарт нөлөөлдөг тухай

4.1. Даатгалын салбарын зохицуулалтын ач холбогдол

Даатгалын зохицуулагч байгууллагын үүргүүд:

- ✓ Даатгалын зохицуулагч байгууллага таван ялгаатай байдлаар үйл ажиллагааны хяналт тавьж ажилласнаар зорилгодоо хүрдэг:
 - Дүрэм журам гаргаж зааварчилгаа өгөх
 - Эрх олгох
 - Хянах
 - Шалгах
 - Хууль мөрдүүлэх
- ✓ Бусад үүргүүд:
 - Компанийн засаглалыг нэмэгдүүлэх
 - Зах зээлийн дэг журмыг сахиулах
 - Хэрэглэгчийн мэдлэгийг нэмэгдүүлэх
 - Нөхөн төлбөрийг зөв зохистой олгуулах

4.1. Даатгалын салбарын зохицуулалтын ач холбогдол

Салбарын зохицуулагч байгууллага нь салбарт үйл ажиллагаа явуулах стандартыг хангуулахын тулд суурь зарчмуудыг тодорхойлж түүнийгээ мөрдүүлэхэд оршдог. Ингэснээр даатгагч, дундын зууч, хэрэглэгчдийн харилцаа илүү урт удаан үргэлжлэх, хэрэглэгчийн салбарт итгэх итгэл нэмэгдэх гол зорилго нь биелэх юм.

Дараах суурь 11 зарчим байдаг:

1. Харилцагчдаа шудрага эрх тэгш хандах	Даатгагч, дундын зууч нар нь харилцагчид үнэн зөв, тодорхой мэдээллээр хангаж тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангана. Үүний тулд: <ul style="list-style-type: none">• Бүх цаг үед шудрага, үнэнч, илэн далангүй үйлдэл хандлага гаргах• Ур чадвартай, анхааралтай, хичээл зүтгэлтэй байна.
2. Хянамгай анхааралтай байх	Даатгагч, дундын зууч нар нь бизнесийн үйл ажиллагаагаа явуулахдаа анхааралтай хянамгай хандана
3. Харилцагчид мэдээллийг бүрэн, үнэн зөвөөр мэдээллэх	Даатгагч, дундын зууч нар нь харилцагчийн мэдэхийг хүссэн мэдээллээр бүрэн дүүрэн хангах, шудрага ил тод байх зарчим баримтална
4. Харилцагчийн тухай мэдээлэл	Даатгагч, дундын зууч нар нь харилцагчаас хүсч буй мэдээлэл нь мэргэжлийн зөвлөгөө өгөх эсвэл гэрээ байгуулах үед ашиглах зорилготой байна

Даатгалын бизнес явуулахтай холбоотой
үндсэн зохицуулалтууд, хуулийн зарчмууд

5. Сонирхлын зөрчил	Даатгагч, дундын зууч нар нь аливаа сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх, ёс зүйн кодоо баримталж ажиллах дотоод бодлог журамтай байна.
6. Зохицуулагч байгууллагатай харилцаатай байх	Даатгагч, дундын зууч нар нь зохицуулагч байгууллагуудтай нээлттэй харилцаж, хамтын ажиллагааг эрхэмлэн ажиллана.
7. Санал гомдол	Даатгагч, дундын зууч нар нь санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх системийг хөгжүүлж ажиллана.
8. Удирдлага ба зохион байгуулалт	Даатгагч, дундын зууч нар нь үр дүнтэйгээр байгууллагыг удирдаж зохион байгуулна
9. Салбарын сахилга бат	Даатгагч, дундын зууч нар нь салбарын зохих ёсны стандартыг судалж хэрэгжүүлэн ажиллана
10. Харилцагчийн хөрөнгө	<i>Insurers and intermediaries must arrange adequate protection for clients' assets when they are responsible for them, not just their own.</i>
11. Харилцагчийн мэдээллийг хамгаалах	Даатгагч, дундын зууч нар нь харилцагчийн хувь хүний болон санхүүгийн мэдээллийг хамгаалах бүх боломжит арга хэмжээг авч ажиллана.

4.2. Даатгагчийн хөрөнгийн хүрэлцээтэй байдал

- ✓ Хөрөнгийн хүрэлцээтэй байдал / capital adequacy
- ✓ Төлбөрийн чадварын үзүүлэлт / solvency margin

Хөрөнгийн хүрэлцээтэй байдлын ач холбогдол:

Хөрөнгийн хүрэлцээтэй байдал, төлбөрийн чадварын үзүүлэлт нь даатгалын зохицуулагч байгууллагын даатгалын байгууллагуудыг хянах чухал үзүүлэлтүүд байдаг. Даатгуулагчийг хамгаалахаас гадна хангалттай хүрэлцээтэй хөрөнгөтэй байх шаардлагууд:

- Даатгалын байгууллагын санхүүгийн тогтвортой байдлын чухал хэмжүүр болдог
- Даатгалын болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах
- Даатгуулагчийн даатгалын зардлыг өсгөхгүй байх
- Зах зээл дээрх даатгагчийн өрсөлдөх чадварт саад учруулахгүй байх

Зохицуулагч байгууллага нь даатгалын байгууллагын даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлж чадахгүй байх эрсдэлээс хамгаалж хөрөнгө болон төлбөрийн чадварын үзүүлэлтэд босго хэмжээ тогтоодог. Жишээ нь: СЗХ-оос тавьдаг шаардлага “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино”

Их Британи-д хамгийн багадаа 100% байх шаардлага тавьдаг. Глобал хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй даатгагчдын харьцаа дунджаар 140-160% орчим байдаг.

4.3. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ба луйвар хэрхэн даатгалын салбарт нөлөөлдөг тухай

Даатгалын байгууллага нь мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх үйлдлийн гол бай болж байдаг. Санхүүгийн гэмт хэргийн нөлөөлөл нь дараах 3 эрсдэлийг бий болгодог ба үүнээс хамгаалах арга хэмжээг авч байх шаардлагатай.

Хуулийн эрсдэл	Даатгалын байгууллага аливаа хууль зүйн зохицуулалтын шаардлагыг хангалгүй шүүхэд дуудагдах, хариуцлагад татагдах, гэрээ хүчин төгөлдөр бус болох эрсдэл үүсч болно
Үйл ажиллагааны эрсдэл	Дотоод хяналтын систем алдагдсанаас санхүүгийн хохиролд өртөж болзошгүй
Нэр хүндийн эрсдэл	Санхүүгийн гэмт хэрэгт холбогдох нь олон нийтийн дунд даатгалын байгууллагын цэвэр, шудрага ажилладаг эсэхэд эргэлзээ төрүүлэх тул үүний улмаас нэр хүндээ алдах эрсдэл үүсч болно.

4.3. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ба луйвар хэрхэн даатгалын салбарт нөлөөлдөг тухай

Санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь:

- ✓ Financial Action Task Force (FATF) – мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхийн эсрэг авах арга хэмжээ, зөвлөмжийг хүргүүлдэг олон улсын байгууллага ба уг байгууллагаас гаргасан 40 зөвлөмжийн дагуу гишүүн байгууллагууд бодлогын түвшинд арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.
- ✓ Харилцагчийн эрсдэл болон нийцлийг шалгах (customer due diligence CDD) – Бизнесийн практикт тохиромжтой эрсдэлийн үнэлгээ хийх хэлбэр бөгөөд энэ нь луйвар, мөнгө угаалт, терроризмийг санхүүжүүлэх зэрэг эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авах, хяналтаа сайжруулах зорилготой.

Луйвар даатгалын салбарт нөлөөлөх нь

Луйвар, цахим гэмт хэрэг нь санхүүгийн бүх салбарт нөлөөлдөг гол эрсдэл байдаг ба даатгалын салбарт нөлөөлж буй нөлөөллийг даатгагч, даатгуулагч аль аль нь зардлаараа үүрэлцдэг эрсдэл юм. Луйвраас үүдсэн хохирол нь даатгагчийн ашиг, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж байдаг. Үүний улмаас даатгагч хураамжийг өсгөснөөр нөгөө талд даатгуулагч илүү өндөр зардлаар даатгал авах болдог. Мөн цаашлаад луйвар, цахим гэмт хэрэг нь хувьцаа эзэмшигч, харилцагчийн итгэл үнэмшлийг сулруулах, даатгагчийн нэр хүндэд нөлөөлөх, салбарын санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй.

Луйвар нь байгууллага доторх болон гаднах нэг хүний үйлдэл эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн нэгдсэн үйлдэл байж болно. Луйврыг дараах гурван төрөлд хувааж болно:

- Дотоод луйвар
- Даатгуулагчийн луйвар, нөхөн төлбөрийн луйвар
- Дундын зуучийн луйвар

5. Даатгалын салбарын ёс зүй, байгууллагын засаглал, дотоод хяналтын тухай

5.1. Ёс зүйн стандартууд

5.2. Компанийн засаглалын тухай

5.3. Дотоод хяналтын системийн ач холбогдол

5.1. Ёс зүйн стандартууд

Chartered Insurance Institute (CII) нь 100 гаруй жилийн түүхтэй даатгалын салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдэд мэдлэг олгох чиглэлтэй байгууллага юм. Энэ хугацаанд дэлхий даяар 150 гаруй улс орны 125,000 гаруй мэргэжилтнүүдийг элсүүлсэн байна.

“CII Code of Ethics” нь бүх гишүүд мэргэжлийн үүргээ биелүүлэх явцдаа дагаж мөрдөх ёс зүйн кодыг томъёолсон байдаг:

“... a powerful tool for members – it is as much a mark of distinction as the designations on your business card. The code is the foundation of trust in you and in your business. The code creates confidence in you and in the industry.”

Дараах 5 гол зарчмыг баримтлах ёстой:

- ✓ Ёс зүйн код болон холбогдох хууль, дүрэм журмыг дагаж мөрдөх
- ✓ Өндөр түвшний ёс зүйн стандарт, шудрага байдлыг эрхэмлэн ажиллах
- ✓ Харилцагч бүрийн хүсэл, сонирхлыг илэрхийлж ажиллах
- ✓ Өндөр түвшний үйлчилгээ үзүүлэх
- ✓ Харилцагчийн нас, хөгжлийн бэрхшээл, хүйс, жирэмсэн төрсөн эсэх, гэрлэсэн байдал, үндэс угсаа, иргэний харъяалал, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага зэргийг үл хамааран хүн бүрт эрх тэгш хандана.

Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого /ESG/

Сүүлийн жилүүдэд байгууллагын хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг хэмжих, үүнийг хэрхэн хэрэгжлүүлж буй байдлаа олон нийтэд мэдээллэх нь байгууллагын нэр хүндэд нөлөө үзүүлдэг болжээ.

- ✓ Байгаль орчин /environmental/ - уур амьсгалын өөрчлөлт, бохирдол
- ✓ Нийгэм /social/ - хүний эрх
- ✓ Засаглал /governance/ - байгууллагын удирлагын чанар

5.2. Компанийн засаглалын тухай

Судалгаагаар даатгалын байгууллагын дампуурал, төлбөрийн чадваргүй болоход ойртсон байдлын шалтгаан нь удирдлагын мэдлэггүй байдал, мэргэжлийн ур чадвар дутмаг байдлаар үйл ажиллагааг явуулах, шудрага байдал алдагдах, зорилгын зөрчил үүсэх, багийн шийдвэр оновчгүй гарах зэргээс үүдэлтэй гэж тодорхойлсон байдаг. Эдгээр бүгдийг нийтэд нь "тохиромжгүй байдал" гэж тодорхойлдог.

Иймд зохицуулагч байгууллагаас нийцлийн шалгалт буюу "тохирсон, зохистой байх шалгуур" /fit and proper requirements/-г "эздүүд болон гол удирдлагад" тавьдаг.

Уг шалгуур үзүүлэлтэд:


- ✓ Ерөнхий шаардлагууд буюу удирдах түвшинд ажиллаж болох мэргэжлийн ур чадвар, туршлага, боловсролын зэргийг шаардана.
- ✓ Гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, аливаа санхүүгийн бүртгэл тайлагнал, удирдлага зэрэгт алдаа гаргаж байсан эсэх, удирдах албан тушаалд ажиллаж байсан түүх, ёс зүйн алдаа дутагдал гаргаж байсан эсэх
- ✓ Өмнөх ажиллаж байсан хугацаандаа шийдвэр гаргалтанд алдаа гаргаж байсан эсэх түүх, удирдах арга барил эзэмшсэн байдлыг тодорхойлох
- ✓ Мэдлэг, мэргэжлийн боловсролын талаар дэлгэрэнгүй түүхийг авах. Үүнд: ажиллах салбарын мэргэжлийн боловсролыг эзэмшсэн, даатгалын үйл ажиллагааны хууль, дүрмийг мэддэг байдал, даатгалын бүтээгдэхүүн, салбарын тухай мэдлэг, даатгалын байгууллагын санхүү, актуар тооцооллын зарчим, давхар даатгалын тухай мэдлэг, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан авч явах мэдлэг зэрэг зүйлс багтдаг.

5.3. Дотоод хяналтын системийн ач холбогдол

Даатгалын байгууллагын дотоод хяналтад дараах гол хэсгүүд багтдаг:

- ✓ Эрсдэлийн удирдлагын хүрээ
- ✓ Нийцэл, дотоод аудитын үүрэг
- ✓ Санал гомдол шийдвэрлэх

Эрсдэлийн удирдлагын хүрээ



Нийцэл, дотоод аудитын үүрэг

Нийцлийг хангах:

- Эрсдэлийг үнэлэх
- Нийцлийн үүргийг тодорхойлох
- Зөвлөх
- Хууль, зохицуулалттай байгууллагын дотоод нийцлийн бодлого тохирч байгаа эсэхийг шалгах, тайлагнах
- Байгууллага зөрчил үүсгэхээс сэргийлэх зөвлөмжийг бэлдэх

Дотоод аудит:

Дотоод аудит нь байгууллагын бүх бүтэц, үйл ажиллагааг хугацааны мөчлөгтэйгээр шалгах, үнэлэх зорилготой. Энэ нь байгууллага бүх түвшиндээ эрсдэлийг удирдах хянах ажлаа хэрхэн гүйцэтгэж байгааг дүгнэх ажил юм.

**Анхаарал хандуулан оролцсон та бүхэнд
баярлалаа!**

PROGRES - Promotion of Growth and Employment in the Private Sector

As a federally owned enterprise, GIZ supports the German Government in achieving its objectives in the field of international cooperation for sustainable development.

Published by:

Deutsche Gesellschaft für
Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

Registered offices
Bonn and Eschborn

PROGRES - Promotion of Growth and Employment in the Private Sector

Deutsche Gesellschaft für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

3rd Floor, Building #38, United Nations Street,

4th Khoroo, Chingeltei District,

Ulaanbaatar 210646, Mongolia

T +976 7011 7704

E giz-mongolei@giz.de

I www.giz.de

Author/Responsible/Editor, etc.:
GIZ, PROGRES PROJECT

Design/layout, etc.:
GIZ, PROGRES PROJECT

Photo credits/sources:
GIZ

URL links:

In cooperation with:

GIZ is responsible for the content of this publication.



**Deutsche Gesellschaft für
Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH**

Registered offices
Bonn and Eschborn

Friedrich-Ebert-Allee 32 + 36
53113 Bonn, Germany
T +49 228 44 60 - 0
F +49 228 44 60 - 17 66

Dag-Hammarskjöld-Weg 1 - 5
65760 Eschborn, Germany
T +49 61 96 79 - 0
F +49 61 96 79 - 11 15

E info@giz.de
I www.giz.de